

ТАНИЛЦУУЛГА

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
тогтоолын төслийн талаар

“Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага” батлах тухай ХХЗХ-ны 2021 оны 63 дугаар тогтоол

Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актад жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр заасны дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан захиргааны хэм хэмжээний актуудад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн зарим хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх шаардлага үүсээд байна.

Дээрх үндэслэлээр Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 63 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг боловсруулсан. Үүнд:

1. Тогтоолын хавсралтаар батлагдсан нөхцөл, шаардлагын доторх үндэслэл болгож эшлэл хийсэн эрх зүйн актууд хүчингүй болсон.

2. УИХ-аас Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хүчингүй болгож, Зөвшөөрлийн тухай хуулийг шинээр баталсантай холбогдуулан нөхцөл шаардлага доторх эшлэл хийсэн заалтад Зөвшөөрлийн тухай хуулийг нэмж оруулахаар төсөлд тусгасан.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны ... сарын ...

Дугаар...

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 63 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Иргэний нисэхийн агаарын холбооны үйлчилгээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага”-ын 3.1.4, 3.1.5, 3.1.6, 5.3, 6.9 дэх хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1.1. Нөхцөл, шаардлагын **3.1.6.** “Радио давтамж ашиглах эрхийн бичиг олгох, түүний хугацааг сунгах, шилжүүлэх, хүчингүй болгох журам /ХХМТГ-ын даргын 2020 оны А/46 дугаар тушаал/,” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, **5.3.** “ИНЕГ-аас бусад агаарын холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь ХХМТГ-ын А/46 тушаалаар батлагдсан “Радио давтамж ашиглах эрхийн бичиг олгох, түүний хугацааг сунгах, шилжүүлэх, хүчингүй болгох журам”-д заагдсан баримт бичгээс гадна ИНЕГ-аас агаарын холбооны үйлчилгээ үзүүлэхийг дэмжсэн албан тоотыг заавал ирүүлнэ.” гэснийг “ИНЕГ-аас бусад агаарын холбооны үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь Зохицуулах хорооноос баталсан бүрдүүлэх баримт бичгээс гадна ИНЕГ-аас агаарын холбооны үйлчилгээ үзүүлэхийг дэмжсэн албан бичгийг заавал ирүүлнэ.” гэж тус тус өөрчлөн найруулах,

1.2. Нөхцөл шаардлагын **3.1.4** дэх заалтаас “/Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн газрын (цаашид ХХМТГ гэх) даргын 2020 оны А/80 дугаар тушаал/,” гэснийг, **3.1.5** дахь заалтаас “(2020-2025)” /ХХМТГ-ын даргын 2020 оны А/149 дугаар тушаал/,” **6.9** дэх заалтын “... болон “Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам” гэснийг тус тус хасах.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /...../-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД:

.....

.....

.....